



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**“ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”
СЭДЭВТ САНХҮҮГИЙН АУДИТ**



Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн актын зарим заалтууд хоорондоо уялдахгүй байна.

**Сайншанд
2018 он**

АГУУЛГА

<p>Тайлан бэлтгэсэн</p> <p>Үндэсний аудитын газрын харъяа Дорноговь аймгийн Төрийн Аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа</p> <p>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ц.Лүндэгмаа</p> <p>Аудитор: О.Нарангарав</p> <p>Аудитор: У.Оюунтүлхүүр</p> <p>2018 оны 11 дүгээр сарын 05</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах асууж лавлах зүйл байвал 70523020 дугаарын утас 70522734 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Дорноговь аймаг Сайншанд сумын 3-р баг Орон нутгийн өмчийн 3 дугаар байр</p>	<p>Товчилсон үгийн тайлбар2</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт 3-4</p> <p>БҮЛЭГ 1: Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй зарим эрх зүйн актууд хоорондоо нийцэхгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн сангийн эрх зүйн орчин оновчтой боловч зарим эрх зүйн актууд хоорондоо нийцэхгүй байна.5-6 • Төрийн сангийн бүтэц нь бодлого чиг үүрэгтэйгээ нийцэхгүй байна.6-9 • Төрийн сан хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч ажлын байрны тодохойлолтод тодорхой тусгаагүй байна.9-10 <p>БҮЛЭГ 2: Төрийн сангийн үйл ажиллагаа бүрэн үр дүнтэй хэрэгжээгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн сангийн төлбөр тооцооны чиг үүрэг, төсөв, мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу бүрэн үр дүнтэй гүйцэтгэж ажиллаагүй байна. ...11-17 • ЗГСУМС-нь хэрэглэхэд ойлгомжтой боловч механик ажиллагаа ихтэй, ид ачааллын үед гацаж уддаг байдал нь төлбөр тооцоо, тайлан мэдээг хугацаанд нь гүйцэтгэх, үнэн зөв байдлыг хангахад эрсдэл үүсгэхээр байна.17-19 • Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна.19-20 <p>Аудитын дүгнэлт21</p> <p>Хавсралт.....22</p> <p>Аудитын зөвлөмж23-24</p> <p>Холбогдох байгууллагын санал25-26</p> <p>Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар27</p> <p>Тушаал баталгаажуулсан тушаал28</p>
---	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮАГ	Үндэсний аудитын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
СЯ	Сангийн яам
ДГА	Дорноговь аймаг
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗГСУМС	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем
НББ	Нягтлан бодох бүртгэл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ССА	Сумын санхүүгийн алба
СХААлба	Санхүүгийн хяналт, аудитын алба
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын А/06 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө, Дорноговь аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны аудит хийх төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилт:

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ.

- Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх
- Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг Дорноговь аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, сумдын Санхүүгийн албаны 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан гүйцэтгэх бөгөөд Аймгийн төрийн сангийн хэлтэс, сумдын төрийн сангийн алба хамрагдана.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын аргазүйг ашиглан Аймгийн Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аргазүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт гаргалаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль

- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Засгийн газрын тогтоол:

- “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” 2015 оны 24 дүгээр тогтоол
- “Санхүүгийн алба байгуулах тухай” 2014 оны 326 дугаар тогтоол

Сангийн сайдын тушаал

- “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” 2012 оны 276 тоот тушаал
- “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам” 2012 оны 294 тоот тушаал
- “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам” 2013 оны 73 тоот тушаал
- “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, арилжааны банканд нээх, хаах журам” Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/А-9 тоот тушаал
- “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам” Сангийн сайдын 2014 оны 65 тоот тушаал
- “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам” 2014/2015 оны 95/129 өөрчлөлт тушаалууд
- “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар” 2015 оны 90 тоот тушаал
- “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам” 2016 оны 415 тоот тушаал
- “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” 2017 оны 216 тоот тушаал

Аудитын хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа хянан удирдаж, аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа үе шатны хяналтыг гүйцэтгэж, санхүүгийн аудитын албаны аудитор О.Нарангарав, У.Оюунтүлхүүр нар гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын ерөнхий зүйл, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

БҮЛЭГ 1

Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй зарим эрх зүйн актууд хоорондоо нийцэхгүй байна.

1.1. Төрийн сангийн эрх зүйн орчин оновчтой боловч зарим эрх зүйн актууд хоорондоо нийцэхгүй байна.

Төрийн сангийн үйл ажиллагааг Монгол улсын төсвийн тухай хуулийн 4.1.40-д “...төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах” гэж томъёолсон байна. Мөн хуулийн 35 дугаар зүйлд “Төрийн сангийн нэгдсэн данс”, 36 дугаар зүйлд төрийн сангийн тогтолцоог аймаг нийслэл, сум, дүүргийн төрийн сан, төсвийн нягтлан бодогчоос бүрдэнэ гэж заасан ба 37 дугаар зүйлд “Төрийн сангийн нийтлэг чиг үүрэг” зэргийг тус тус тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд Төрийн сангийн нийтлэг чиг үүргийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

37.1.1. Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих;

37.1.2. Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх;

37.1.3. Төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх;

37.1.4. Төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох;

37.1.5. Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих;

37.1.6. Төсвийг бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх;

37.1.7. Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг НББ-ийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах;

37.1.8. Төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох зэрэг

Төрийн сангийн үйл ажиллагаанд дээрх нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч “төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг Төсвийн тухай хуулиар хуульчлан баталснаас хойш Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг Засгийн газраас 3 удаа өөрчлөн найруулсан байна. Үүнд: Засгийн газрын 2012 оны 205 тоот тогтоол, 2013 оны 287 тоот тогтоол, 2015 оны 24 тоот тогтоолууд тус тус гарсан байна.

Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зарим хууль, тогтоомжийн заалтууд хоорондоо уялдахгүй, хэрэгжихгүй байна. Тухайлбал,

- Төсвийн тухай хуулийн 36.2-т заасан “Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна” гэж заасан

байхад аймгийн төрийн сан нь ЗДТГ-ын дэргэд бус, ЗДТГ-ын бүтэц орон тоонд багтаж байгаа нь уг заалттай нийцэхгүй байна.

- Төсвийн тухай хуулийн 36.3, 36.4-т "НББ-ийн үйлчилгээ үзүүлэх алба байгуулах асуудлыг СЯ-ны зөвшөөрснөөр аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ" гэж заасан байтал Засгийн газар 2014 оны 326 дугаар тогтоолоор сумдад Санхүүгийн алба байгуулсан. Уг Засгийн газрын тогтоол нь МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т "Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг ЗГ-аас тогтоох бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ нь хэлтэс, тасагтай байна" гэсэн заалтыг үндэслэсэн нь Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4 дэх заалтуудтай зөрчилдөж байна.
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам" хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ба 6.1.2-т "аймаг, нийслэлийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг" 6.2.2-т "сум, дүүргийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг" гэсэн заалтууд нь Төсвийн тухай хуулийн 2015 оны шинэчилсэн найруулгаар хүчингүй болсон байна.
- Төсвийн тухай хуулийн 35.5-д "Банканд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ." гэж заасан боловч тухайн шатны төрийн сан нь энэ заалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрэн бүрдээгүй байна. Жишээлбэл, Аймаг, сумын төрийн сан нь төсвийн байгууллагын арилжааны банкин дах дансны мэдээллийг Сангийн ямаар дамжуулан авдгаас цаг тухайд нь мэдээллийг хүлээн авч, хяналт тавьж чадахгүй байна.

1.2. Төрийн сангийн бүтэц, зохион байгуулалт нь бодлого чиг үүрэгтэйгээ нийцэхгүй байна.

Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2014 оны А/578 тоот захирамжаар сумдад төрийн сангийн дарга, мэргэжилтэн, харьяа төсвийн байгууллагын нягтлан бодогчдыг хамруулан албаны бүтэц, орон тоог тогтоож санхүүгийн алба байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/340 тоот захирамжаар Сайншанд, Замын-Үүд суманд санхүү, төрийн сангийн тасаг байхаар өөрчлөлт оруулсан нь Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолтой нийцэхгүй байна. Учир нь Засгийн газар 2014 оны 326 дугаар тогтоолоор Сумын Засаг даргын Тамгын газарт сумдад үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлт хариуцсан Санхүүгийн албыг байгуулахаар тогтоосон.

Сумын төсвийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих төрийн сангийн нэгжийн бүтцийг сумын санхүүгийн албаны дарга, төсвийн мэргэжилтэн, төсвийн байгууллагын нягтлан бодогчдоос бүрдүүлж зохион байгуулсан нь төдийлөн оновчгүй

байна. Тухайлбал: Үйлчлүүлэгч байгууллагынхаа нягтлан бодогчийг өөрийн бүтцэд харьяалуулж байгаа нь төрийн сангаас төсөвт байгууллагуудын төлбөр тооцоонд тавих дотоод хяналтыг сулруулах эрсдэлтэй байна.

2017 оны байдлаар 14 суманд санхүүгийн албаны дарга, Сайншанд сумын 5 дугаар багт төрийн сангийн төлөөлөгч нийт 15 хүн төрийн сангийн чиг үүргийг удирдан хэрэгжүүлэхийн зэрэгцээ сумын статистик мэдээ тайлан гаргах, тусгай сангуудын үйл ажиллагааг давхар хариуцан ажиллаж байна.

Сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын ачаалал харилцан адилгүй байгаагаас зарим мэргэжилтэнд хэт ачаалал үүсэж, хяналтын тогтолцоо алдагдах эрсдэлийг бий болгож байна. Хүснэгтээр 2017 оны гүйлгээний тоо мэдээг харуулав.

№	Төрийн сангийн нэгж	Төрийн сангаар үйлчлүүлдэг Байгууллагын тоо	Бүртгэлтэй дансны тоо	ТС-ийн мэргэжилтний тоо	2017 онд хийсэн гүйлгээний тоо	Гүйлгээний мөнгөн дүн /тэр бум төгрөг/
1	Аймгийн төрийн сан	34	129	3	18311	44.9
2	Сайншанд сумын санхүүгийн тасаг	22	59	1	7795	12.6
	Сайншанд сумын 5-р баг /Зүүнбаян/	8	16	1	2809	4.4
3	Замын Үүд сумын санхүүгийн тасаг	23	51	1	7161	27.8
4	Алтанширээ сумын санхүүгийн алба	6	32	1	2039	1.4
5	Дэлгэрэх сумын санхүүгийн алба	6	32	1	2090	1.6
6	Иххэт санхүүгийн алба	6	34	1	1568	1.9
7	Өргөн санхүүгийн алба	6	33	1	2135	2.2
8	Эрдэнэ санхүүгийн алба	6	35	1	2327	6.3
9	Улаанбадрах санхүүгийн алба	6	34	1	2625	2.2
10	Хатанбулаг санхүүгийн алба	6	38	1	2885	7.3
11	Хөвсгөл санхүүгийн алба	6	32	1	1870	1.7

Хүснэгтээс харахад:


- Сайншанд сумын 5-р багт Төсвийн тухай хуулиар заагдаагүй тосгоны төрийн сангийн нэгж, сумын төрийн сангийн статусаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.
- Ажлын ачаалал харилцан адилгүй байгаагаас гүйлгээ хугацаандаа хийгдэхгүй байх, үйлчлүүлэгч байгууллагаас гүйлгээний ажилтанд найр тавих асуудал үүсэж байгаа бөгөөд, цаашид ажлын ачааллыг жигдрүүлж, бүтэц орон тоонд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Сумдад санхүүгийн алба байгуулах тухай Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор суманд 2 нягтлан бодогч, аймгийн төв болон 8001-ээс дээш хүн амтай суманд орон тооны дээд хязгаар 3 байхаар тогтоосон. Дорноговь аймгийн хувьд: сумдад орон нутгийн төсвийн байгууллагын-1, эрүүл мэндийн төвийн-1, боловсролын салбарын-1

нийт 3 нягтлан бодогч ажиллаж байна. Харин Замын-Үүд, Сайншанд сумдад санхүүгийн алба байгуулах, төсвийн 3-5 байгууллагын дунд нэг нягтлан бодогч томилох гэсэн заалт хэрэгжих боломжгүй байна. Учир нь эдгээр сумдын нягтлан бодогчид 1-2 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Сумдад ажиллаж байгаа нягтлан бодогч нь 2-3 төсөвт байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж байгаагаас сар, улирлын сүүлчээр ажлын ачаалал их болж үндсэн ажлаа ажлын цагт хийх боломжгүй, илүү цагаар ажилладаг байна. Сумдын нягтлан бодогч нар давхар ажил хийсний урамшуулал, нэмэгдэл цалин хөлс авдаггүй, өөрөөр хэлбэл нэг байгууллагын цалингаар бусад байгууллагын санхүүгийн ажлыг гүйцэтгэж, гарах хариуцлагыг үүрч ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь заалт болон Сангийн сайдын 2012 оны 94 дүгээр тушаал "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 3.1.9, 3.1.10-т "аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт харьяалагдах байгууллагын ахлах нягтлан бодогчийг байгууллагын дарга аймгийн СТСХ-ийн даргатай зөвшилцөн томилно" гэж заасны дагуу төсвийн шууд захирагч нар нягтлан бодогч нарыг томилдог байна. Схемээр харуулбал:



Харин Сайншанд, Алтанширээ сумдын төсвийн байгууллагын нягтлан бодогчдыг сумын Засаг дарга томилж байгаа нь дээрх хууль журмуудыг зөрчиж байна. Тухайн байгууллагын бүтэц орон тоонд харьяалагддаг нягтлан бодогчийг сумын Засаг даргаас

томилох нь төсвийн шууд захирагчаас тухайн албан хаагчийн ажлыг дүгнэх, хариуцлага тооцох зэрэгт сөргөөр нөлөөлөхөөр байна.

Аймгийн нийт 14 сумдаас түүвэрлэн 10 сум, аймгийн төрийн сангийн үйл ажиллагаатай танилцан холбогдох асуулга, судалгааг авсан.

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлагатай байна уу гэсэн асуулгад төрийн сангийн дарга, мэргэжилтэнгүүд дараах хариултыг өгсөн байна. Үүнд:

- 6 сумын төрийн сангийн дарга, мэргэжилтэн төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэх, сайжруулах шаардлага одоогоор байхгүй байна
- 4 сумын төрийн сангийн албан хаагчид Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан нэршлийн дагуу албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэх шаардлагатай байна гэж хариулсан байна. Учир нь уг тогтоолд төрийн сангийн мэргэжилтэн гэж зааж өгсөн байхад Засгийн газрын 2017 оны 354 дүгээр тогтоолд уг албан тушаалын нэршил байхгүй байдаг.

Аудитын явцад түүвэрт хамрагдсан сумдаас судалгаа хийхэд 2017 оны байдлаар сумдын санхүү албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч нар ТЗ-6 ангиллаар цалинжиж байгаа нь Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоосон Засгийн газрын 354 дүгээр тогтоолд сумын төсвийн ерөнхий нягтлан бодогчийг ТЗ-5 ангиллаар цалинжина гэж заасантай зөрчилдөж байна. Харин төрийн сангийн мэргэжилтэн гэсэн ангилал байхгүй тул ажлын байрны тодорхойлолтыг төрийн сангийн ажилтан болгон томилж ТҮ-8 ангиллаар цалинжуулж байна.

Санхүү албаны дарга бөгөөд сумын ерөнхий нягтлан бодогч нарыг ТЗ-5 шатлалаар цалинжуулбал төрийн сангийн ажилтнаасаа доогуур цалинжихаар байдаг тул шатлалыг албаны дарга буюу ахлах мэргэжилтэнтэй дүйцүүлэн ТЗ-6 шатлалаар нь цалинжуулдаг гэсэн тайлбарыг өгч байлаа.

1.3. Төрийн сан хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч ажлын байрны тодорхойлолтод тодорхой тусгаагүй байна.

Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор жишиг чиг үүрэг, Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тогтоолоор "Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар", аймгийн Засаг даргын 2018 оны А/340 дүгээр захирамжаар сумдын ЗДТГ-ын ажлын байрны чиг үүргийг тус тус баталсан байна.

Түүвэрт хамрагдсан сумдын санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийг Сангийн сайдын 2015 оны 90-р тогтоолоор баталсан ажил үүргийн жишигтэй харьцуулахад дараах байдалтай байна.

№	Сумдын нэр	Жишиг тодорхойлолтод тусгагдсан заалт	Ажлын байрны тодорхойлолтод тусгасан заалт
Төрийн сангийн дарга			
1	Алтанширээ, Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ	26	21-24
2	Замын-үүд, Дэлгэрэх, Иххэт, Улаанбадрах, Сайншанд		12-17
Төрийн сангийн мэргэжилтэн			
1	Эрдэнэ, Замын-үүд, Иххэт	15	10-13
2	Өргөн, Хатанбулаг, Хөвсгөл		6-8
3	Сайншанд, Алтанширээ, Дэлгэрэх, Улаанбадрах		3-5

Төрийн сангийн дарга, мэргэжилтэн нь ажлын байрны жишиг зааварт тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. Гэтэл жишиг зааварт тусгагдсан дараах ажлуудыг ажлын байрны тодорхойлолтод дутуу тусгасан байна. Үүнд:

- мемориалын баримтыг тулган, архивын нэгж үүсгэх,
- гарын үсгийн баталгааг хянан, хүлээн авах,
- дансны үлдэгдлийн баталгааг хагас, бүтэн жилээр гаргуулан баталгаажуулах
- албаны дотоод ажил хариуцах

Мөн төрийн сангийн мэргэжилтний ажил үүргийн жишиг зааврын 1-3 заалтыг сумдын санхүүгийн албаны дарга хийж гүйцэтгэдэг байна. Үүнд: Сумын статистик мэдээллийн нэгтгэлийг холбогдох тасаг, нэгж албан тушаалтнаас ирүүлсэн мэдээнд үндэслэн боловсруулж холбогдох байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг удирдлагаар батлуулах зэрэг ажил болно.

Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар “Орон нутгийн санхүү, төрийн сангийн албан тушаалтнуудын ажил үүргийн жишиг заавар”-ын дагуу төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Дорноговь аймгийн ЗДТГ нь Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Хууль эрхзүйн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Төрийн захиргаа удирдлагын хэлтэс гэсэн 6 хэлтэстэй.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн хувьд бусад хэлтэстэй давхардсан чиг үүрэг байхгүй байна.

БҮЛЭГ 2

Төрийн сангийн үйл ажиллагаа бүрэн үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байна.

2.1 Төрийн сангийн төлбөр тооцооны чиг үүрэг, төсөв, мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтыг хууль тогтоомжийн дагуу бүрэн үр дүнтэй гүйцэтгээгүй байна.

Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, Сангийн сайдын 2016 оны 431 тоот тушаалаар батлагдсан “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг заавар”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, сайжруулалт, хяналт тайлагналын журам”-ын холбогдох заалтын дагуу төрийн сан болон төсөвт байгууллагууд нь төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ гэж заасан байдаг.

Аудитаар аймгийн болон 10 сумын төрийн сан, тухайн төрийн сангуудаар төлбөр тооцоог хийж гүйцэтгэдэг 88 байгууллагыг түүвэрлэн сонгож, тэдгээрийн санхүүгийн холбогдох баримтуудыг татан авч үзсэн болно. Хүснэгтээр харуулав.

№	Төрийн сангийн нэгж	Төрийн сангаар үйлчлүүлдэг Байгууллагын тоо	Бүртгэлтэй дансны тоо	Үүнээс түүвэрт хамрагдсан байгууллагын тоо	Сонгон үзсэн санхүүгийн баримт
1	Аймгийн төрийн сан	34	129	13	2017 оны 3, 6, 10, 12, 2018 оны 3, 5-р дугаар сарууд
2	Сайншанд сумын санхүүгийн тасаг	22	59	11	2017 оны 1 3, 6, 10, 12 дугаар сарууд
	Сайншанд сумын 5-р баг /Зүүнбаян/	8	16	4	
3	Замын Үүд сумын санхүүгийн тасаг	23	51	12	2017 оны 2, 8, 9, 12, 2018 оны 1, 6-р дугаар сарууд
4	Алтанширээ сумын санхүүгийн алба	6	32	6	2017 оны 2, 3, 6, 12, 2018 оны 1, 4-р дугаар сарууд
5	Дэлгэрэх сумын санхүүгийн алба	6	32	6	
6	Иххэт санхүүгийн алба	6	34	6	
7	Өргөн санхүүгийн алба	6	33	6	
8	Эрдэнэ санхүүгийн алба	6	35	6	2017 оны 1,2,9,11,12
9	Улаанбадрах санхүүгийн алба	6	34	6	
10	Хатанбулаг санхүүгийн алба	6	38	6	
11	Хөвсгөл санхүүгийн алба	6	32	6	
	Нийт	135	525	88	


Төрийн сангийн төлбөр тооцоотой холбоотойгоор төрийн сан болон төсөвт байгууллагуудад 2017 онд дараах алдаа зөрчил гарсан байна. Үүнд:

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8¹, Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, сайжруулалт, хяналт тайлагналын журмын 4.3², 4.11³-д заасныг зөрчиж анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, төлбөрийн хүсэлт засвартай байхад ажил гүйлгээг явуулсан байна. Тухайлбал:

- Сайншанд сумын төрийн сан нэхэмжлэх байхгүй, томилолтын хуудсыг дүгнэж зөвшөөрөл олгоогүй баримтаар 1.9 сая төгрөгийн гүйлгээг хийсэн
- Замын Үүд сумын төрийн сан томилолтын хуудсыг дүгнэж зөвшөөрөл олгоогүй, тооцоо бодолт буруу баримтаар 0.8 сая төгрөгийн гүйлгээг хийсэн
- Аймгийн төрийн сан хөрөнгө оруулалтын дараах ажлуудад нийт 409.7 сая төгрөгийн урьдчилгаа болон үе шатны ажлын санхүүжилтийг гүйцэтгэл бичиж ирүүлээгүй байхад гүйлгээг хийсэн.
 - Иргэдийн хөгжлийн төвийн барилгын 40.0 сая төгрөг
 - Айраг сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл 156.7 сая төгрөг
 - Эрдэнэ сумын дулаан, цэвэр бохир шугамын ажлын 213.0 сая төгрөг

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.5⁴, 7.13.5⁵. 8.4⁶ дахь заалтуудыг зөрчиж зарлагын гүйлгээг хийх эрх бүхий 1 дүгээр гарын үсгийг зурдаг албан тушаалтан нь гарын үсгийн дардас ашигласан, 1 болон 2 дугаар гарын үсэг зурагдаагүй, төлбөрийн хүсэлтэд засвар хийгдсэн, засвар хийсэн хэсэгт байгууллагын тамга, санхүүгийн тэмдэг дараагүй баримтаар гүйлгээг ЗГСУМС-д бүртгэжээ. Тухайлбал:

- Замын Үүд сумын Гаалийн газрын дарга, Хүүхдийн 4-р цэцэрлэгийн эрхлэгч нар төлбөрийн хүсэлтийн 1-р гарын үсгийг гарын үсгийн дардас ашиглан гүйцэтгэсэн - 8 баримт 23.9 сая төгрөг
- Сайншанд, Замын Үүд сумдын төрийн сан төлбөрийн хүсэлтийн 1, 2-р гарын үсгийн аль нэг гарын үсэг зурагдаагүй, тамга, тэмдэг дарагдаагүй, төлбөрийн хүсэлт засвартай, төлбөрийн хүсэлтээс зөрүүтэй зэрэг 16 баримтаар 11.1 сая төгрөгийн,
- Улаанбадрах, Хөвсгөл сумын төрийн сан төлбөрийн хүсэлтэд засвар хийсэн, тамга тэмдгээр баталгаажуулаагүй 39 баримтад 43.3 сая төгрөгийн,
- Сайншанд, Хөвсгөл сумын төрийн сан төлбөрийн хүсэлтийн дүнгээс зөрүүтэй 20.2 сая төгрөгийн гүйлгээг тус тус хийсэн.



¹ төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг үндэслэх баримтын эх хувь, хяналтын хуудасны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад: худалдан авахтай холбоотой үнэлгээний хорооны шийдвэр, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бусад бичиг баримт хамаарна. Үндэслэх баримтын мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцана.

² Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн кахиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэт болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулна.

³ Захиалагч барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралт, их засварын ажлын календарчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж ирүүлнэ.

⁴ Тухайн байгууллага бүртгэлийн данснаас гүйлгээ хийхдээ байгууллагын 1 болон 2 дугаар гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажсан төлбөрийн хүсэлтийг ...Төрийн санд хүргүүлнэ.

⁵ энэхүү журмын 7.1, 7.2, 7.3-г заасан бүрдэл болоогүй гарын үсгээр гүйлгээ хийх

⁶ Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана.

Мөн дээрх журмын 8.2⁷-дах заалтыг зөрчин гүйлгээг хийдэг Тухайлбал,

- *Замын Үүд сум, Улаанбадрах, Сайншанд сумын төрийн сангууд 40.9 сая төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэхдээ ажлын 3 хоногоос хэтэрч гүйлгээг хийсэн.*
- *Улаанбадрах сумын төсөвт байгууллагууд нь оны эхний төлбөрийн хүсэлтийг өмнөх оны санхүүгийн баазад шивж хийдгээс төлбөрийн хүсэлтийн он бүтэн 1 жилийн өмнөхөөр хэвлэгдэж, хэвлэгдэж гарсан хойно нь засвар хийж байгууллагын тамга, тэмдэг дарж баталгаажуулдаг байна. Үүнтэй холбоотой зарим төлбөрийн хүсэлтийн огноог засаагүй баримтад архивласан байна.*

Тайлант хугацаанд Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11, 7.12 дахь заалтаар зөвшөөрөгдөөгүй, 7.13.3-д заасныг зөрчиж орлого бууруулах бичилт хийсэн байна. Тухайлбал,

- *Аймгийн төрийн сан нь аймгийн Засаг даргын тамгын газрын 94.7 сая төгрөгийн гүйлгээг орон нутгийн санхүүжилт бууруулан,*
- *Сайншанд сумын төрийн сан орон нутгийн санхүүжилт бууруулан 3 байгууллагын 46.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээг,*
- *Замын Үүд сумын төрийн сан 15.6 сая төгрөгийн гүйлгээг санхүүжилт бууруулан хийсэн байна.*

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.14⁸-т заасныг зөрчиж нэр болон данс, эдийн засгийн ангилал зөрүүтэй, данс болон байгууллага андуурч гаргасан зарлагын гүйлгээнд мемориалын ордер үйлдээгүй, бичсэн боловч үндсэн баримтыг хавсаргаагүй байна. Тухайлбал,

- *ЗГСУМС-д алдаатай шивсэн гүйлгээг залруулахдаа Сайншанд сумын төрийн сан 168.3 сая төгрөгийн, Замын Үүд сум 202.8 сая төгрөгийн, Өргөн сумын төрийн сан 12.3 сая төгрөгийн мемориалын ордер үйлдсэн боловч үндэслэх баримтыг хавсаргаагүй.*
- *Аймгийн төрийн сангийн хувьд 2017 оны эхний 9 сарын 152.4 сая төгрөгийн залруулах гүйлгээг үндсэн баримтгүй хийсэн,*
- *Хөвсгөл сумын төрийн сан 10.0 сая төгрөгийн, Хатанбулаг сумын төрийн сан 13.5 сая төгрөгийн, гүйлгээг залруулахдаа мемориалын баримт үйлдээгүй байна..*

Сайншанд сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодогчид эдийн засгийн ангилал, зардлын дансыг андууран гүйлгээ хийдгээс 2017 онд 9.6 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтгүй төрийн сангийн даргаар залруулгыг шууд хийлгэсэн байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8.6⁹, 8.7¹⁰ дахь заалтыг зөрчин анхан шатны баримтуудад төрийн сангийн тэмдэг дараагүй болон гарын үсгээр баталгаажуулаагүй байна. Тухайлбал:

- *Замын Үүд сумын төрийн сан төсөвт байгууллагуудын 2017 оны 1-9 сар хүртэлх санхүүгийн анхан шатны баримтуудад төрийн сангийн тэмдэг дарж баталгаажуулаагүй байна.*
- *Замын Үүд, Сайншанд, Хөвсгөл сумдын төрийн сан 27.5 сая төгрөгийн гүйлгээний төлбөрийн хүсэлтэд тамга тэмдэг дараагүй, гарын үсэг зураагүй байна.*

Жич: Зөрчлийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт №1-ээр харуулав.

⁷ Төрийн сан нь төрийн сангийн төлбөр тоцооны системд бүртгэгдсэн зарлагын гүйлгээг төсвийн байгууллагын төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн баталгаажуулж, ажлын 3 хоногт багтаан эцсийн төлбөр гүйцэтгэх үүргийг хариуцна

⁸ Төрийн сан төсвийн байгууллагын ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг системд бүртгэхдээ нэр, данс, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллыг буруу шивсэн баталгаажуулаагүй зарлагын гүйлгээг залруулах тохиолдолд энэхүү журмын 7 дугаар хавсралтад заасан ТТ-7 маягтыг үйлдэн тухайн байгууллагын үндсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг хавсаргаж 1 дүгээр гарын үсгийг Төрийн сангийн хэлтэс, албаны дарга, 2 дугаар гарын үсгийг гүйлгээ хариуцсан мэргэжилтэн нар зурж баталгаажуулан залруулна.

⁹ Төрийн сан төсөвт байгууллагын төлбөрийг гүйцэтгэхдээ үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган төрийн сангийн тэмдэг дарна.

¹⁰ Төсвийн байгууллага нь төлбөрийн хүсэлтийн үндэслэх баримтуудад Төрийн сангийн тэмдэг дарагдсан эсэхийг гүйлгээ хийсэн тухай бүр хянаж байна.

Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдын төрийн сангууд Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 11.5-т “төрийн сангийн нэгжийн өдрийн мемориалын бүрдүүлбэрт тухайн өдрийн дансны хуулга, зарлагын гүйлгээний жагсаалт, гүйлгээний төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлт орно” гэж заасан байхад сарын хуулгаар мемориалын баримтыг бүрдүүлэн архивын баримтыг үүсгэдэг. Энэ нь төрийн санд үлдэж буй төлбөр тооцооны баримтаас алга болох эрсдэл үүсэж байна.

Хатанбулаг, Хөвсгөл сумдын төрийн сан 2017 оны бэлэн мөнгөний чекийг мемориалын баримт болгож архивын баримт болгоогүй байна. Эдгээр сумдын төрийн сангийн мэргэжилтнүүд журмыг бүрэн судалж ажилдаа мөрдөөгүйгээс дээрх баримтын бүрдүүлбэр ямар бүтэцтэй байх талаар ойлголтгүй байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны 5-р зүйлд “Төрийн санд бүртгэлийн данс нээх, хаах” заалтын дагуу аймгийн төрийн сан 2017 онд шинээр 2 данс нээлгэх, ашиглагдахгүй байгаа 107 дансыг хаалгах, 3 дансны нэрийг өөрчлөх хүсэлтүүдийг Сангийн яаманд хүргүүлэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын явцад орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төсвийн байгууллагууд Төсвийн тухай хуулийн 35.3¹¹ дахь заалт, Сангийн сайд болон Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/А-9 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банканд нээх хаах журам”-ыг зөрчиж зөвшөөрөлгүйгээр арилжааны банкуудад данс нээсэн байна. Тухайлбал,

- Аймгийн ГХБХБГ нь газрын төлбөрийн орлого төвлөрүүлэх тэг үлдэгдэлтэй дансыг нээлгэх хүсэлтийг хүргүүлэн Төрийн банканд 2016 онд 281500372356 тоот дансыг нээж, орсон төлбөрийг Төрийн сангийн Газрын төлбөрийн 100060000943 дансанд төвлөрүүлж байна. 2017 оны эцэст 144192 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан. Уг дансыг Сангийн яам болон Төрийн банкны хамтарсан 2016 оны “Арилжааны банканд тэг үлдэгдэлтэй данс нээх, түүний төлбөр тооцоог зохицуулах 164/17/26/1136 тоот гэрээний 3.4¹² дахь заалт, 8.7¹³ дахь заалтуудыг зөрчин нээсэн болно.
- Улаанбадрах сумын Засаг дарга сумын Нүдэн багт данс нээх хүсэлтийг суман дахь Төрийн банканд хүргүүлэн 2017 оны 8 сард 281000077015 тоот дансыг нээж, хандивын мөнгө авч хөрөнгө бэлдсэн байна. Уг дансыг 2018 оны 01 сарын 18-д хүсэлт хүргүүлэн хаасан байна.

➤ Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын дагуу явагдаж байгаа үйл ажиллагаатай танилцахад ихэнх төсөвт байгууллагууд жижиг мөнгөн сангийн дансгүй, аймгийн төв болон сумдын төсөвт байгууллагууд Төрийн банканд байршиж буй төрийн сангийн бэлэн мөнгөний дансаар дамжуулан бэлэн мөнгөний төлбөр тооцоог хийж гүйцэтгэдэг байна.

Аймгийн төвийн төрийн сангийн харьяа байгууллагуудын бэлэн мөнгөний чекийн 1-р гарын үсгийг Төрийн сангийн дарга, 2-р гарын үсгийг аймгийн ерөнхий нягтлан бодогч, сумдын бэлэн мөнгөний чекийн 1-р гарын үсгийг сумын Засаг дарга, 2-р гарын үсгийг санхүү албаны дарга нар зурж байна.

¹¹ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ.

¹² Гэрээний хавсралтад заасан данснаас өөрөөр аливаа хэлбэрээр банк, төсвийн байгууллага данс нээхийг хориглоно.

¹³ Банк нь гэрээний хавсралтад заасан данснаас өөрөөр аливаа хэлбэрээр данс нээхийг хориглоно. Шаардлагатай тохиолдолд гэрээний хавсралтад Сангийн яамны зөвшөөрснөөр нэмэлт өөрчлөлт орсон тухай бүр дансыг бүртгэнэ

Мөнгөн кассын ажиллагааны журмын 2.2¹⁴, 2.3¹⁵, 6.3¹⁶ дахь заалтуудыг зөрчин бэлэн мөнгөний гүйлгээг хийж, мөнгийг гарган авч бараа материал бэлдсэн байна. Тухайлбал,

- Замын Үүд сумын ЗДТГ 2 удаагийн гүйлгээгээр 16.9 сая төгрөгийг бэлнээр гарган авч, тоног төхөөрөмж, эд хогшил, бичиг хэрэг болон цэвэрлээгээ, ахуйн хэрэглээний бараа материалыг бэлтгэсэн байна.
- Хатанбулаг сумын сургууль 3 удаагийн гүйлгээгээр 4.2 сая төгрөгийн сургалтын материалыг .
- Улаанбадрах сумын Эрүүл мэндийн төв 1.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, ЗДТГ 1.3 сая төгрөгийн бараа материалыг бэлэн мөнгөөр тус тус бэлтгэсэн байна.
- Хөвсгөл сумын Засаг дарга 2017 оны 7 сарын 6-ны өдөр бэлэн мөнгөний чекийн 1-р гарын үсийг зурж, өөрөө 3.5 сая төгрөгийг хүлээн авсан байна.

➤ Сангийн сайд болон Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/А-9 тоот тушаалын 4.4 дахь заалтын үндэслэн Сангийн яам болон Төрийн банкны хамтарсан 2016 оны “Арилжааны банканд тэг үлдэгдэлтэй данс нээх, түүний төлбөр тооцоог зохицуулах 164/17/26/1136 тоот гэрээ байгуулан гэрээний хавсралтаар орлого төвлөрүүлэх “Тэг” үлдэгдэлтэй дансны жагсаалтыг баталсан байна.

Уг гэрээний хавсралтаар Дорноговь аймагт орлого төвлөрүүлэх татварын 17 дансыг жагсаалтаар баталсны дагуу Төрийн банк төвлөрсөн орлогуудыг төрийн сангийн татварын орлогын холбогдох данс руу төвлөрүүлж байна.

Гэрээний 5.1-д “Банк нь гэрээний хавсралтад заасан дансанд төвлөрсөн орлогыг төрийн сангийн холбогдох данс руу тухайн ажлын өдрийн Монгол банкны банк хоорондын их дүнтэй гүйлгээ дамжуулах сүүлийн гүйлгээний цагт шилжүүлж байна” гэж заасан байтал банк төвлөрсөн орлогыг 5-8 хоногт, дээд тал нь 27 хоногийн дараа төвлөрүүлж, сарын эцэст Тэг үлдэгдэлтэй гарсан байна.

Хувь хүний орлогын албан татварын 280500348629 тоот дансанд 2017 оны 09 сарын 21 өдөр 10.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснийг харьяа төрийн сан, татварын хэлтсийн байцаагч мэдээгүй, банк уг орлогыг төвлөрүүлээгүйгээс 2017 оны эцэст үлдэгдэлтэй гарсан.

Дээрх дансны үлдэгдлийг 2018 оны 02-р сарын 07-ны өдөр төрийн сангийн холбогдох дансанд төвлөрүүлэн дансыг хаасан байна.

Жагсаалтаар батлагдсан “Тэг” үлдэгдэлтэй 17 данснаас 2018 онд 2 дансыг аймгийн татварын хэлтсийн албан бичгийн дагуу хаасан байна.

➤ Төсвийн тухай хуулийн 4.1.27-д “орон нутгийн төсөв” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг хэлнэ гэж тодорхойлсноор 2017 оны аймгийн төсвийг Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар

¹⁴ Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картан дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар/ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно.

¹⁵ Журмын 2.2-д зааснаас бусад зардлаас зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв, бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгаж ирүүлнэ. Төрийн сан албан хүсэлтийг хянаж үзэн, шаардлагатай гэж үзвэл бэлнээр олгож болно.

¹⁶ Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ- 500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна.

сарын 05-ны өдрийн 03/05 дугаар тогтоолоор баталж, сумын ИТХ-аар төсвөө хугацаанд нь баталж ажилласан байна. 2017 онд аймгийн төсөвт 2 удаа, сумдад мөн 1-2 удаа тодотгол хийж шат шатны ИТХ-аар батлуулан ажилласан байна.

“Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 4.2-т заасны дагуу Тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн сар улирлын хуваарьт зохицуулалтыг хийхдээ тухайн байгууллагад төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай албан бичиг байхгүй байна.

Замын-Үүд, Өргөн, Иххэт, сумдын сургууль цэцэрлэгийн баримтад зохицуулалт хийсэн төсөв байхгүй, байгууллагууд нь өөрчлөлтийг төлөвлөгөөнд тусгаагүйгээс гүйцэтгэлийн мэдээ нь хэтрэлттэй харагдаж байна. Мөн сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулахдаа гүйцэтгэл гарсан зардлын төлөвлөгөөг бууруулснаар жилийн дундуурх сарын мэдээнд зардлууд нь хэтрэлттэй харагдаж жилийн эцсийн дүнгээр хэтрэлтгүй гүйцэтгэлтэй гарсан байна.

Энэ нь аймгийн БСУГ-ын төсөв хариуцсан мэргэжилтэн төлөвлөгөөний сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулахдаа гүйцэтгэл, төсвийг хянаж хийгээгүйгээс болсон байна. Тухайлбал: Замын-Үүд сумын 3-р сургууль, 2-р цэцэрлэг, Өргөн сумын сургууль цэцэрлэг

Зарцуулалтын эрхийг нээсэн байдлыг freebalanced програмд тулгаж үзэхэд эрхийг баталсан төсвийн дагуу нээсэн мөн зардлыг дарааллын дагуу санхүүжүүлсэн байна.

Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журам"-ын 5.2¹⁷ заалтыг зөрчсөн дараах нийтлэг зөрчлүүд гарч байна. Тухайлбал:

- Зарцуулах эрхийн хүсэлт баталгааны санхүүжилтийн эх үүсвэр болон зарцуулалтын эрх нь сар улирлын хуваарьт нийцэхгүй байх. /Иххэт, Замын-үүд, Өргөн Алтанширээ/
- Байгууллагын болон төрийн сангийн баримтуудад зарцуулах эрхийн хүсэлт баталгаа байхгүй байх /Замын-Үүд, Иххэт, Дэлгэрэх, Өргөн /

Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн журам"-ын 4.3, 4.4-т заасны дагуу зарцуулалтын эрхийг нээж төсвийн зарцуулалтын эрх сар, улирлын хуваарьт нийцэж байгаа эсэхийг түүвэрлэсэн хугацаанд гарсан төсвийн хэлбэлзлийн тайлантай тулгаж шалгаж үзэхэд зөрүү байхгүй байх боловч сарын гүйцэтгэлийн мэдээгээр батлагдсан төсөв зөрүүтэй байна. Энэ нь тухайн байгууллага төсвийн сар улирлын хуваарьт гарсан өөрчлөлтийг программдаа нэмж оруулаагүйгээс болсон байна. Тухайлбал:

- Замын-Үүд сумын 3-р сургууль төлөвлөгөөний өөрчлөлтийг оруулж өгөөгүй, ЗДТГ нэмэлтийн мэдээ байхгүй

-Өргөн сумын эрүүл мэндийн төв төлөвлөгөөг программд орлого зарлагыг оруулахдаа 218.0 мянган төгрөгөөр зөрүүтэй,

¹⁷ Төсвийн санхүүжилт болон зарцуулалтын эрх нь тухайн байгууллагын батлагдсан төсвийн сар улирлын хуваарьт нийцсэн байна.

Түүвэрт хамрагдсан байгууллагуудад төсвийн гүйцэтгэлээс эдийн засгийн ангилал, бүлгийн дүнгээр хэтэрсэн зардлуудад зохицуулалт хийхдээ албан бичиг, зөвшөөрсөн шийдвэр, холбогдох баримттай байна.

2017 онд урьдчилан тооцож олгосон нэмэлт орлого жилийн эцсийн гүйцэтгэлээс хэтэрсэн байдал түүвэрлэсэн байгууллага болон сонгосон хугацаанд гараагүй бөгөөд Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн “Орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлэх журам, түрээсийн гэрээний загвар, түрээсийн гэрээний төлбөрийн доод үнэ батлах тухай” 10 дугаар тогтоолын 2-р хавсралтын 2.4-т Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн 50 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ гэж заасны дагуу 2017 онд 49.8 сая төгрөг, 2018 оны эхний хагас жилд 17.9 сая төгрөгийг төрийн албан хаагчдын орон сууц, спорт зал, сурталчилгааны самбар гэх мэт эд хөрөнгийн түрээсийн орлогоос орон нутгийн орлогод төвлөрүүлж ажилласан байна.

Дэлгэрэх сумын ЗДТГ-ын нэмэлт орлогын тухайн жилд зарцуулаагүй үлдэгдэл 25.0 мянган төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлсэн боловч авлага үүсгээгүй байсан. Мөн Өргөн сумын 3 байгууллагын нэмэлт орлогын 2,408.7 мянган төгрөгийн үлдэгдлийг орон нутагт төвлөрүүлсэн боловч одоо болтол эргэн хуваарилаагүй байна.

2.2. ЗГСУМС-нь хэрэглэхэд ойлгомжтой боловч механик ажиллагаа ихтэй, ид ачааллын үед гацаж уддаг байдал нь төлбөр тооцоо, тайлан мэдээг хугацаанд нь гүйцэтгэх, үнэн зөв байдлыг хангахад эрсдэл үүсгэхээр байна.

Аймгийн бүх сумд байнгын цахилгаан эх үүсвэрт 2017 онд холбогдож дууссантай холбогдон ЗГСУМС-д 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс бүх сумд бүрэн холбогдсон байна. ЗГСУМС-ийг хэрэглэж байгаа төрийн сангийн 16 хэрэглэгчдээс системийн хэрэглээний талаарх санал асуулга судалгаа авч үзэхэд тус программ нь хэрэглэхэд ойлгомжтой гэж 12 хэрэглэгч хариулсан байна.

Тулгарч буй асуудал, хүндрэл бэрхшээл хэсэгт дараах саналууд асуулга тус бүр дээр ирсэн байна.

1. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг хэрэглэхэд ойлгомжтой байдаг уу? гэсэн асуулгад
 - Программыг хэрэглэхэд ойлгомжтой байдаг. /12 сум/
 - Программын талаар дахин сургалт авмаар байна. /4 сум/
2. ЗГСУМС нь таны ажил үүргийг гүйцэтгэх шаардлагыг хангаж, үйл ажиллагааны хамрах хүрээг бүрэн хамарч чаддаг уу?
 - Төсөв зоохоос бусад асуудал шийдэгдсэн.
 - Программд гар ажиллагаа их шаарддаг кэйбоард дээр таб товчны ашиглалтыг илүү сайжруулах шаардлагатай, программын өмнөх хувилбар төсвөөр ороод бүх зардлыг гүйлгэж харж болдог байсан бол одоо нэг бүрчлэн зардлын зүйлээр орж харж байгаа болохоор хугацаа их шаардаж байна. Мөн мэргэжилтэн байгууллагын гүйлгээг хийхэд зардал хүрч хийгдсэн мөртлөө дотоод хяналт гүйлгээ хийхэд зардал хүрэхгүй гарч ирдэг.

- Дотоод хяналтын мэргэжилтнүүдэд сумдын шивсэн гүйлгээг хянах боломжгүй
3. ЗГСУМС -д өгөгдөл оруулах, боловсруулах, тайлан мэдээ гаргах явцад саатал бэрхшээл тохиолддог уу?
- Төсвийн хуваарьт орсон өөрчлөлтийг системд шивэх эрхийг зөвхөн Сангийн яам эзэмшдэг. Ингэхдээ сард нэг л удаа таталт хийдэг нь зайлшгүй шаардлагатай тулгамдсан үед аймаг сумандаа орсон өөрчлөлтийг хийж өгдөггүйгээс хүнд суртал үүсдэг. Үүнийг аймагт нэг эрх нээчихвэл шийдвэрлэх боломжтой гэж хардаг. Сарынхаа мэдээг системээс шууд боловсруулдаг эрхийг аймагт нээж өгөх шаардлагатай. Энэ эрхийг нээснээр сарын мэдээний гүйцэтгэлийг үнэн зөв шуурхай гаргах боломжтой
 - Өгөгдөл оруулахад болон тухайн байгууллагын регистр өөр нэр нэмж оруулах тохиолдолд зарим нэгэн засвар үйлчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахад хүндрэлтэй байдаг.
4. Таны хэрэглэж буй компьютер техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал бүрэн хангагдсан уу?
- Техник хэрэгслийн ашиглалтын хугацаа дуусаж эвдэрснийг засуулах шаардлагатай-2
 - Компьютер техник хэрэгслийн хүчин чадал муу-1
5. Санал хүсэлтийн хэсэгт
- Байгууллагын дансны хуулганы үлдэгдэл программын үлдэгдэлтэй таардаггүй. Харилцагч байгууллагын данс заримдаа устсан байдаг. Байгууллагуудын гүйлгээ буцдаг.
 - Сонголтоо хийж дуудаж гарч ирсний дараа мауз авчихад хөтөлбөр зориулалтын нэр нь харагддаг бол буруу бол дахин хандах зэргээр хугацаа их авч байна.
 - Сарын эцэс болон ачааллын үед систем гацах, удах, тасрах явдал их гардаг

ЗГСУМС-д мөрдөх журмын 2.4-д “Системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн ээлжийн амралт, гадаад болон дотоод томилолт, хүүхэд асрах чөлөөтэй, түр хугацааны чөлөөтэй байх хугацаанд системийн нэр, нууц үгээ шилжүүлэх тохиолдолд харьяа нэгжийн удирдах албан тушаалтны холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн эрхийг шинэ хэрэглэгчид шилжүүлж, тухай бүр харьяа аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст албан бичгээр мэдэгдэж байна” гэж заасны дагуу түүвэрлэлтэд хамрагдсан 10 сум болон аймгийн төрийн санд тухайн хугацаанд тус журмаар баталсан маягт №1-ээр 30 удаа түр эрх шилжүүлсэн байна.

Харин журмын 2.6-д тухайн төсвийн жилийн системийн хэрэглэгч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд тухайн хэрэглэгчийн эрхийг хязгаарлах, шинэ хэрэглэгчийг бүртгүүлэх тухай албан хүсэлтийг Төв төрийн санд аймаг нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтсээр дамжуулан Төрийн захиргааны төв байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын газар, хэлтэс холбогдох тушаал шийдвэрийн хамт хүргүүлнэ гэж заасны дагуу 2017, 2018 онд нийт 11 удаа батлагдсан Маягт-2 болон

холбогдох тушаал шийдвэрийг аймгийн төрийн сангийн хэлтэст хүргэж архивын нэгж үүсгэн ажилласан байна.

Аймгийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн улирал бүр гардаг ЗГСУМС-д нэвтрэн ажилласан хэрэглэгчдийн бүртгэлийн судалгааг хугацаанд нь гаргаж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд функционал администратор систем дэх хэрэглэгчдийн эрхийн хязгаарлалтыг дунджаар 10 хоногийн дотор журмын дагуу хийж гүйцэтгэж байна. Системийн тохиргоо, өөрчлөлт хийх эрх бүхий албан тушаалтнууд хязгаарлалт хийх тохиолдол гарч байгаагүй байна

ЗГСУМС-д мөрдөх журмын 2.7-д “хэрэглэгч өөрийн нууц үгээ алдсан, бусдад мэдэгдсэн байж болзошгүй гэж таамагласан даруйдаа нууц үгээ өөрчилж байна, гэж заасан байхад Өргөн сумын төрийн сангийн Санхүүгийн албаны даргын нууц үгийг мэргэжилтэн нь мэдэж программд нэвтэрч байсан нь хяналт болон системийн аюулгүй ажиллагаа алдагдаж мэргэжилтэн гүйлгээ хийж батлах бүрэн боломжтой байна.

Аймгийн хэмжээнд системийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор мөрдөж буй дүрэм, хэрэгжилтийг хангах талаар тусдаа гарсан дүрэм, журам байхгүй зөвхөн Сангийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 95 тоот тушаалын хавсралт болох ЗГСУМС-д мөрдөх журмаар зохицуулан ажиллаж байна.

2.3. Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлснээр үйл ажиллагаа сайжирсан байна.

“Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3 –т “Төлөвлөгөөт хяналтыг хийх календарчилсан төлөвлөгөөг жил бүрийн эхний улиралд багтаан Төв төрийн сан Сангийн сайдаар, аймаг, нийслэлийн төрийн сан Засаг даргаар тус тус батлуулан мөрдөнө” гэж заасан байна. Мөн Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үр дүнгийн гэрээнд төрийн сангийн дотоод хяналт шалгалт явуулах төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллах талаар тусгагдсан байна.

Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх журмын дагуу аймгийн төрийн сангийн өдөр тутмын болон системийн хяналтыг хэрэгжүүлж, төсөвт байгууллагуудын буруу шивсэн гүйлгээ, дансны улайлт, орлого бууруулсан гүйлгээ зэргийг цаг тухайд нь арилгуулж ажилласан байна.

2017 онд “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 5.1-д заасан аргачлалын дагуу сумдаас эрсдэлийн үнэлгээг албан бичгээр, цахимаар буюу дотоод сүлжээгээр аван нэгтгэн тодорхойлж ажлын календарчилсан төлөвлөгөөг гарган аймгийн Засаг даргаар батлуулан ажилласан байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу 14 сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийж дууссан байна.

2018 онд сумдаас эрсдэлийн үнэлгээг авалгүй өөрсдийн тогтоосон эрсдэлийн үнэлгээгээр эрсдэлийг тооцож аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/197 захирамжаар өндөр эрсдэлтэй гарсан 8 суманд дотоод хяналт явуулахаар

календарчилсан төлөвлөгөө гарган батлуулсан байх бөгөөд Сайхандулаан сумаас бусад сум хугацаандаа явагдаж байна. Сайхандулаан сумын шалгалт нь аймгийн ЗДТГ-ын шалган туслах ажлын хэсэгтэй хамтран явахтай холбоотой хойшлогдсон байна.

Аймгийн төрийн сангийн дотоод хяналтын шалгалтыг сумдын ажлын байранд очиж хийж алдаа зөрчлийг газар дээр нь засаж залруулж зөвлөгөө өгөн шалгалтын дүнгийн хурлыг төрийн сангийн дарга, мэргэжилтэн, засаг дарга бусад удирдах албан тушаалтныг оролцуулан хийж дүгнэлт, зөвлөмжийг гарган танилцуулж хяналт шалгалтад хамрагдсан сумдын засаг дарга нарт танилцуулж, гарын үсэг тамга даран баталгаажуулан хувийг өгч ажиллажээ. 2017, 2018 онд шалгалтад хамрагдсан сумдад нийт 44 зөвлөмжийг өгч хугацаанд нь биелэлтийг гаргуулан авч ажилласан байна.

Дотоод хяналтаар илэрсэн зөрчлүүдийг нэгтгэн үзвэл:

- “Төсвийн тухай” хууль болон “Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх журам”, бусад хууль тогтоомж журмыг сахиж ажиллах

- Санхүүгийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд ажил үүргийг тодорхой оруулж өгөх,

- Гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл бичилтийг хянаж ажиллах

- Төрийн сангийн архивын нэгжийг дараа өдөрт нь багтаан хянан тулгаж, мемориалын баримтыг үүсгэн санхүү албаны даргад хянуулж, архивын нэгж үүсгэж хэвших

- Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд өглөг авлагын тооцоо нийлсэн актаар баталгаажуулан хүлээн авах

- Төсөвт байгууллагын ирүүлсэн мэдээг программд үнэн зөв мэдээлэх, хяналтыг хэрэгжүүлэх гэсэн нийтлэг зөвлөмжүүд гарсан байна.

Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд өдөр тутмын системийн хяналт хийх боломжгүй байдаг ба аймгийн хэмжээний нийт хийгдсэн гүйлгээ, болон алдаатай болон орлого бууруулсан гүйлгээг өдөр тутамдаа харж хянах боломжгүй байдаг байна.

Мөн 2017 оны 10 сард аймгийн хэмжээнд санхүүгийн албаны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлыг ахлах мэргэжилтэн, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй Аймгийн засаг даргын баталсан удирдамжтай шалгалтыг хийсэн байна.

Уг шалгалтаар Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх журмуудын хэрэгжилт хангалтгүй, ЗГСУМС-д алдаатай шивэгдсэн хэдий ч банк хооронд буцаагдсан гүйлгээнд төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу мемориалын баримт үйлдээгүй, тухайн гүйлгээний төлбөрийн хүсэлт, албан тоотыг авч ажиллаагүй, Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээ зөрүүтэй баталгаажуулсан, анхан шатны баримт бүрдэл дутуу, шаардлага хангахгүй зэрэг зөрчил гарсан байна.

2017 онд хийсэн дотоод хяналтын шалгалт болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт шалгалтаар гарсан алдаа зөрчлийг арилган засаж залруулан ажилласан нь 2018 оны дотоод хяналт шалгалт болон аудитын явцад харагдаж байна. Иймээс дотоод хяналт үр нөлөөтэй сайн зохион байгуулагдаж байна гэж үзэж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар хэрэгжүүлсэн арга зүй, горим, судалгааны дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ✚ Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн актын зарим заалтууд нь хоорондоо уялдахгүй байна.
- ✚ Орон нутгийн салбар, нэгжүүдийг Засаг даргын дэргэд байгуулах тухай Төсвийн тухай хуулийн заалт хэрэгжээгүй байна.
- ✚ Сайншанд, Алтанширээ сумын Засаг дарга нар нягтлан бодогчдыг томилж байгаа нь Төсвийн тухай хууль, Сангийн сайдын журмын холбогдох заалтуудыг зөрчиж байна.
- ✚ Төсвийн хэрэгжилтийг хууль дүрэм журмын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа боловч төрийн сан болон нягтлан бодогчдоос шалтгаалсан алдаа зөрчил гарсаар байна.
- ✚ Төрийн сангийн мэргэжилтэн архивын нэгжийг дараа өдөрт нь багтаан хянан тулгах, мемориалын баримтыг үүсгэн санхүү албаны даргад хянуулах, архивын нэгж үүсгэх ажлуудыг сайжруулах шаардлагатай байна.
- ✚ ЗГСУМС- нь хэрэглэхэд ойлгомжтой боловч гар ажиллагаа их шаардагддаг, сарын сүүлээр болон ачаалал ихтэй үед гацах удах явдал их байгаагаас сарын эцсийн гүйлгээ хийх, орлого төвлөрүүлэхэд хүндрэлтэй байдаг байна.
- ✚ Төрийн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр дүнтэй хэрэгжсэнээр 2018 онд гарсан зөрчлийн тоо өмнөх оноос эрс буурсан байна.
- ✚ Аудитаар төрийн сангийн үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс түүврээр судалгаанаас нийт 1.3 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илэрлээ. Төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын ачаалал харилцан адилгүй, эрхэлж байгаа ажил үүрэгтэйгээ холбоотой хууль, журмуудыг судлах, хэрэгжүүлэх ажиллагаа дутмаг, хайхрамжгүй байдал зэрэг нь дээрх зөрчил, дутагдал гарахад нөлөөлж байна.

Аудитаар нийт 1.3 тэрбум төгрөгийн зөрчлийг /хавсралт 1/ илрүүлж, холбогдох 8 газарт 12 зөвлөмж, 1 албан шаардлага өгөв.

Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан зөрчлийн жагсаалт
/ сая төгрөг /

№	Төрийн сангийн нэр	Зөрчигдсөн журмын заалтууд												Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам		Нийт дүн			
		төрийн сангийн үйл ажиллагааны журам												баримт тоо	мөнгөн дүн	баримт тоо	мөнгөн дүн	баримт тоо	мөнгөн дүн
		баримт тоо	мөнгөн дүн	баримт тоо	мөнгөн дүн	баримт тоо	мөнгөн дүн	баримт тоо	мөнгөн дүн	баримт тоо	мөнгөн дүн	баримт тоо	мөнгөн дүн						
		7.5, 7.13.5, 8.4	7.8, 7.13.7	7.11, 7.12, 7.13.3	7.14	8.2	8.6, 8.7	2.2, 2.3, 6.3											
1	Аймгийн төрийн сан			46														46	656.8
2	Сайншанд сумын төрийн сангийн тасаг	6	1.7	16		8	1											33	220.2
3	Замын Үүд сумын төрийн сангийн тасаг / Дардас - 8 - 23.9/	13	25.6	4		25	12											61	315.6
4	Алтанширээ сумын төрийн сан																	0	-
5	Дэлгэрэх сумын төрийн сан																	0	-
6	Ихсэт сумын төрийн сан																	0	-
7	Өргөн сумын төрийн сан																	0	-
8	Улаанбадрах сумын төрийн сан	9	9.3				2											13	12.3
9	Хатанбулаг сумын төрийн сан																	3	4.2
10	Хөвстөл сумын төрийн сан	32	34.1															32	17.7
11	Эрдэнэ сумын төрийн сан																	0	44.1
	Нийт дүн	60	70.7	66	0	33	15	157.1	559.3	31.6	7	24.6	7	23.7	188	1,279.4			

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад

1. Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдлөг болгож буй хууль журмын заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах талаар төрийн сангийн албан хаагчид болон нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулах
2. Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11 дэх хэсгийг баримтлан төсвийн байгууллагын санхүүжилтийн орлогыг шууд бууруулсан гүйлгээг хийхгүй байх
3. Дотоод хяналтын мэргэжилтэн төрийн сангийн дотоод хяналтын календарьчилсан төлөвлөгөөг гаргахдаа “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 5.1-д заасан аргачлалын дагуу сумдын төрийн сангийн эрсдэлийг анхан шатнаас нь авч нэгтгэн үнэлсний дараа батлуулж байх.
4. Байгууллагын нягтлан бодогчдыг томилохдоо Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь заалт болон Сангийн сайдын 2012 оны 94 дүгээр тушаал "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 3.1.9, 3.1.10-т заасны дагуу аймаг, сумын төсөвт харьяалагдах байгууллагын ахлах нягтлан бодогчийг байгууллагын дарга аймгийн СТСХ-ийн даргатай зөвшилцөн томилж байгаа эсэхэд хяналт тавих.

Сайншанд сумын Засаг даргад

1. Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11 дэх хэсгийг баримтлан төсвийн байгууллагын санхүүжилтийн орлогыг шууд бууруулсан гүйлгээг хийхгүй байх.
2. Байгууллагын нягтлан бодогчдыг томилохдоо Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь заалт болон Сангийн сайдын 2012 оны 94 дүгээр тушаал "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 3.1.9, 3.1.10-т заасны дагуу аймаг, сумын төсөвт харьяалагдах байгууллагын ахлах нягтлан бодогчийг тухайн байгууллагын дарга аймгийн СТСХ-ийн даргатай зөвшилцөн томилж байх.

Замын-Үүд сумын Засаг даргад

1. Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11 дэх хэсгийг баримтлан төсвийн байгууллагын санхүүжилтийн орлогыг шууд бууруулсан гүйлгээг хийхгүй байх

Алтанширээ сумын Засаг даргад

1. Байгууллагын нягтлан бодогчдыг томилохдоо Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь заалт болон Сангийн сайдын 2012 оны 94 дүгээр тушаал "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 3.1.9, 3.1.10-т заасны дагуу аймаг, сумын төсөвт харьяалагдах байгууллагын ахлах нягтлан бодогчийг тухайн байгууллагын дарга аймгийн СТСХ-ийн даргатай зөвшилцөн томилж байх

Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумын Засаг дарга нарт

1. “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.5-д заасны дагуу Төрийн сангийн архивын нэгжийг дараа өдөрт нь багтаан хянан тулгаж, мемориалын баримтыг үүсгэн санхүү албаны даргад хянуулж архивын нэгж үүсгэж хэвших.

Өргөн сумын Засаг даргад

1. Сангийн сайдын 2014 оны 95 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын Системийн хэрэглэгч өөрийн нууц үгээ алдсан, бусдад мэдэгдсэн байж болзошгүй гэж таамагласан даруйдаа нууц үгээ өөрчилж байна гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон,
Утас/факс: (705) 2-30-03
E-mail: dornogobi_mgl@yahoo.com

2018.11.08 № 3/1894

танай _____ -ны № _____ -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн сэдэвт санхүүгийн аудитын төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүллээ.

Хавсралт: ... хууластай.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ

03 1378

**Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн сэдэвт санхүүгийн аудитын
төсөлд өгөх санал**

Дотоод хяналтын мэргэжилтэн төрийн сангийн дотоод хяналтын календарчилсан төлөвлөгөөг гаргахдаа “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 5.1-д заасан аргачлалын дагуу сумдын төрийн сангийн эрсдлийг анхан шатнаас нь авч нэгтгэн үнэлэн батлуулж байх.

1. 2017 онд төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын дагуу сумдаас эрсдлийг үнэлэн авч нэгтгэж оруулсан боловч сумдаас ирүүлсэн эрсдлүүд бага эрсдэлтэй буюу төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх шаардлагагүй гэж гарч байгаа тул тухайн онд сумдад хийгдэх төлөвлөгөөт шалгалтын эрсдэл нь үнэн зөв гарахгүй байна.

2. 2018 онд төрийн сангийн үйл ажиллагааны эрсдлийг үнэлэхдээ өнгөрсөн оны төрийн сангийн дотоод хяналт шалгалтын эрсдлийг үндэслэн өндөр болон дунд эрсдэлтэй гарсан сумдыг төрийн сангийн дотоод хяналтын календарчилсан төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан ажиллаж байна. Иймээс сумдын төрийн сангийн эрсдлийг анхан шатнаас авч нэгтгэхээр үнэн зөв гарахгүй байгаа тул өнгөрсөн оны төрийн сангийн дотоод хяналтын эрсдлийг үндэслэн гаргаж байх шаардлага гарч байна.

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 5.2-т “төлөвлөгөөт хяналт шалгалтыг явуулахдаа төрийн сангийн дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан жил бүрийн эхэнд төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдлийг журамд заасан аргачлалын дагуу үнэлж, төлөвлөгөөт хяналтын календарчилсан төлөвлөгөөг жил бүрийн эхний улиралд багтаан аймгийн Засаг даргаар батлуулан мөрдөнө” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа талаар тайланд бичсэн тул дээрх саналыг нэмэх шаардлагагүй болно.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/25

Дорноговь аймаг, Сайншанд сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.12, 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Монгол улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”, 2017 оны 188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУ-ын Ерөнхий аудиторын баталсан 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, аймгийн Төрийн аудитын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн “2018 оны Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” сэдэвт аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Лүндэгмаа/-д үүрэг болгосугай.
4. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Алтанширээ, Замын-Үүд, Өргөн, Сайншанд, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

9625968

САНХҮҮГИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АУДИТОР	О.НАРАНГАРАВ
АУДИТОР	У.ОЮУНТҮЛХҮҮР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ	Ц.ЛҮНДЭГМАА
--	-------------

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ч.АРИУНАА
-----------------------------	-----------

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД

ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.